



## THE WORLD OF THE LOTUS SUTRA

### Цагаан Лянхуа Цэцэгийн Судар- Элбэт

Сургалтанд цугларсан хүмүүс ба цуглараагүй хүмүүс зөгнөлийн үг авсан тухай 9-р бүлэг

Уран Аргын 2-р бүлэгт Шаарийбуу,Зөгнөлийн Үгийн тухай 6-р бүлэгт Дөрвөн Агуу Шёмон,500 шавь зөгнөлийн үг авсан 8-р бүлэгт Пурна ба 1200 хүн Будда болох зөгнөлийн үг авсаныг хараад хамгийн сүүлд хоцрон үлдсэн Ананд ба Рахүра хоёр шавь өөрийн эрхгүй гунигт автагдав.Тэгээд тэд ч мөн зөгнөлийн үг авч чадвал хичнээн баяртай зүйл вэ гэж бодоод.”Бидэнд ч Будда болохыг зөгнөж өгнө үү”гэж гуйв.Тэгтэл сургалтанд цугларан ирсэн байсан сурагчид ба сургаалыг сураад дууссан сурагчид бус гэсэн 2000 хүн суудлаасаа босож,нэгэн зэрэг алгаа хавсруулан Шагжамүниг дээдлэн харангаа Ананд ба Рахүратай адилхан бодлыг зүрх сэтгэлдээ бодож мөргөцгөөв.

Үүнийг харсан Шагжамүни нь тэр хоёрт зөгнөлийн үгээ хэлж,Анандад уул далайтай адил Агуу Гүн Бүхнийг Нэвтрэн Хардаг Оюун Ухааны Хаан гэсэн нэр өгч,түүний эзэмших орны нэрийг “Ямагт Өргөсөн Байдаг Ялалтын Туг”гэж нэрлэв.

Гэтэл дөнгөж зөгнөлийнхөө үгээ аваад зориг эрмэлзлэлтэй болсон бусад бодисадва нар Ананд нь хэнээс ч илүү их нэр хүндтэй зөгнөл авсныг гайхан сэжиглэв.

Үүнийг анзаарсан Шагжамүни нь бүх хүмүүст хандаж ингэж хэлэв:

“Би өмнөх насандаа Анандтай хамт гэгээрэлд хүрч,Будда болоё гэж шийдсэн билээ.Гэвч Ананд аль болохоор олон сургаал сурья гэдэг байсан бол би аль болохоор сурсан сургаалаа биелүүлэхийг хичээдэг байв.Тийм ч учраас би түүнээс нэг алхамаар хурдан Буддагийн гэгээрэлд хүрсэн юм.Гэсэн ч Ананд энэ насандаа ч өнгөрсөн насны учралын холбооноос миний шавь болж,миний сургаалыг хамгаалан биелүүлж,ирээдүйд ч олон будда нарын сургаалыг олон түмэн шавь нартаа сурган дамжуулж тэдний даяаныг гүйцэтгэн биелүүлж чадна.Ананд ямагт олон зүйл асууж байдаг

учраас та бүгд түүнийг Шёмон гэж боддог байсан байх.Гэвч түүний чин сэтгэл нь ийнхүү юм.Тиймээс ч би түүнд саяны зөгнөлийг хэлсэн юм”.

Анандын зөгнөлийг хэлж дуусаад Шагжамүни нь дараагаар нь Рахүрад хандаж ийнхүү хэлэв:

“Чи бол Долоон Эрдэний Цэцгэн дээр Алхсан Будда болно.Будда болох нас ба бусад бүх зүйл чинь Анандтай адил байх болно”Мөн дараагаар нь нэмж хэлэв.”Рахүрагийн нууцлаг зан үйлийг би л сайн мэднэ.Түүний хийсэн буян бол тоолж барашгүй бөгөөд тэрээр хэзээ ч Буддагийн сургаалын замнаас мултарч байгаагүй.Тэр бол бодисадвагийн замаар явж Хязгааргүйн Гэгээрэлд хүрэхийг хүсэж байгаа.”

Тэр үед Шагжамүни сурагч ба сурагч бус 2000 хүний байдлыг ажиглан харж,бүгд уян зөөлөн бөгөөд нөхцөл болзолд автагдаагүй ариун сэтгэлээр Шагжамүнид хандаж байгааг хараад:

“Энд байгаа бүх хүмүүс Эрдэний Тэмдэг гэсэн нэртэй Будда болно”гэж зөгнөн хэлэв.

Үүнийг сонссон бүх хүмүүс нэгэн зэрэг баярлан үсэрч.”Шагжамүни Та бол бидний найдварын гэрэл мөн.Бид бүхэн Будда болох баталгаа авч үнэхээр сэтгэл дүүрэн жаргалтай байна” гэж хэлэн талархалаа илэрхийлэв.



## Зовлон шаналгааны үндэс

Шагжамүни хамгийн сүүлд бид нарт өвөглөн үлдээсэн сударт ингэж өгүүлэгдсэн байв:

“Олон шуналтай хүн олон эрх ашгийг шаарддаг боловч түүнчлэн сүүлдээ олон шаналгаа зовлонтой болдог”. Тийм ч юмтай болмоор байна, ийм ч юмтай болмоор байна гэж ямагт шунаж эцэст нь бүх юм холигдож будилан зовж зүдэрдэг хүмүүс бидэнд энэ нь хатуу үг юм.

Ялангуяа улирал солигдох үед орчин тойрныхоо зүйлсээ янзалж байхдаа үүнийг мэдэрдэг юм. Жишээлбэл, төрөл бүрийн сонин сэтгүүл цуглуулж хэзээ нэгэн цагт дотроос нь сонирхолтой хэсгийг нь хайчилж авна гэж бодсоор байгаад хаяж ч чадахгүй, эргээд уншиж ч чадахгүй баахан бичиг цаасны дунд толгойгоо барин зовдог. Хичнээн “Хайран юм” гэж бодсон ч толгойгоо сэргээж цэгцлэхийн тулд юуны өмнө ойр хавиа цэвэрлэж янзлах шаардлагатай.

Сурган хүмүүжүүлэгч Мори Шинми гуай хүндэт багшийнхаа өрөөнд анх ороход ширээн дээр нь ганц номноос өөр зүйл байгаагүй байсан гэдэг. Хүн ийнхүү эхлээд орчин тойрныхоо юмаа цэгцэлж л бие сэтгэлээ ч засаж авч чаддаг бөгөөд сурах чадвар ч улам гүнзгийрдэг байна.

Гэвч ихэнх хүмүүс хальж дүүрсэн зүйлээр өөрийгөө хүрээлж, янзлах байтугай бие сэтгэлийнхээ ачааг улам хүндрүүлэн байдаг байна. Энэ бол зовлон шаналгааныхаа үндсийг өөрөө тавьж байгаа гэсэн үг юм.



Дээр өгүүлсэн Шагжамүнигийн судрын үргэжлэл нь ийнхүү билээ:

“Хэрэв та зовлонгоосоо чөлөөлөгдөө гэж хүсвээс ханахыг сур. Ханахын сургаалыг эзэмшвэл амгалан сайхан болно”.

Бид шунал хүслээ хаяж чадахгүй байх. Харин “Ханахыг мэддэг сэтгэл”-тэй болбол бие сэтгэл маань хөнгөрөх байх.

## Бусдад ашиг өгөх

“Сэтгэлдээ шийдсэн юмандаа тэмүүлэх” гэсэн утгатай “тэмүүлэл” гэсэн япон ханз нь “арав”, “нэг” ба “сэтгэл” гэсэн гурван ханзнаас бүрддэг билээ. Үүнийг “Арван шуналыг нэг болгож чаддаг сэтгэл” гэж унших бөгөөд хүний сэтгэлд буцалсан олон шуналыг нэгэн зүйлд төвлөрүүлж, бусдын аз жаргалын төлөө гэсэн Буддагийн хүсэлд тэмүүлэн зорьж явах бид бүхний “тэмүүлэл” юм. Тийм ч учраас шунал хүсэлдээ автагдсан үедээ энэхүү “тэмүүлэл” гэсэн үгийн утгыг эргэн санах нь “ханахыг мэддэг сэтгэл”-дээ буцаж чадах нэгэн арга билээ.

Мөн бид шийдэх аргагүй будилаантай хүнд асуудалтай учирсан үед, эсвэл том цочирдол авсан үед сэтгэлээ цэгцэлж бодож чадахгүй болдог. Шууд дайрч хэлбэл бүгд “өөрийн санасны дагуу” биш учраас зовлон болдог байна. Үүнийг “Учрал холбогдолын сургаал”-иар авч үзвэл зовлонгийн үндэс нь юу байна, явал зовлонгоосоо ангижирч сэтгэл тайвширахаа олж харж чадна.

Гэтэл нүдний өмнө тулгарсан үзэгдэлдээ сэтгэл автагдаж, энэхүү сургаалын үнэнийг харж чадахгүй болдог байна.

“Хязгааргүйн сургаал”-д: “Хөрөнгө

өмчинд автагдсан хүнд хаях сэтгэлийг, харамч хүнд хандивлах сэтгэлийг үүсгэж өгнө үү” гэсэн үг байдаг.

Ийнхүү хүн ямар нэгэн зүйлд автагдаж, зовлонгоосоо чөлөөлөгдөхийг хүсвэл өдөр бүрийн амьдралдаа юуны өмнө бусдын төлөө, бусдын ашгийг илүүд бодох хэрэгтэй.

“Хаях сэтгэл” гэдэг нь өмч хөрөнгөөс гадна биеэ тоосон байдал, алба тушаалынхаа ашиг хонжоо гэсэн зүйлийг ч “хаяна” гэсэн утгатай. “Хандив өргөх сэтгэл” гэдэг нь шууд утгаасаа гадна бас жишээлбэл, дараачийн хүний сэтгэлийг бодож жорлонгийнхоо таглааг доош нь харуулж таглах гэх мэтийн мэдээжийн зүйлийн утгатай юм.

Хүн өдөр бүрийнхээ амьдралаа ийнхүү бусдын сэтгэлийг бодож өнгөрөөвөл аяндаа “ханадаг сэтгэл”-тэй болдог байна.

Орчин тойрноо цэгцлэн янзлах, сэтгэлээ цэгцлэх явдал нь бүгд бидний “тэмүүлэл”-ээс хамаарна.

“Косэй” 2012 оны 3 сарын дугаараас



# Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч  
Нивано Коошо багш

## Муу хүн ба сальфетка

Италичууд жаахан хүүхдийг их өхөөрддөг. Тэр тусмаа ази гаралтай япон хүүхэд бол ховор болоод ч тэр үү би хүүхдүүдээ дагуулаад гадаа гарахад бараг алхам болгонд л хүмүүс “Ямар хөөрхөн юм бэ”, “Нэрийг нь хэн гэдэг вэ?” гэх мэтээр асууж сонирхсоор бид очих гэсэн газартаа ч бараг хүрж чадалгүй байдаг байв. Гэвч үүний ачаар нөхөр бид хоёр зөвхөн бие биендээ ч биш бас нийгэмд ч ач холбогдолтой хүнлэг хүмүүс байна гэдгийг мэдэрч чадсан юм. Энэ нь нутгаасаа хол амьдарч байсан бид хоёрт маш чухал зүйл байв.

Нэг удаа гудамжинд том охинтойгоо хамт алхаж байтал юм зарж байсан африк гаралтай нэг залуу “Ямар хөөрхөн хүүхэд вэ, нэрийг нь хэн гэдэг юм?” гэж асуув. Тэрхүү агшинд миний толгойнд аюулын хонх зурвасхийгээд өнгөрөв. Охиныхоо гарыг чанга атгаад анзаараагүй дүр үзүүлээд явчихсан юм. Охин маань гайхсандаа “Тэр хүн муу хүн юм уу?” гэж асуув. “Үгүй дээ, муу хүн биш байх. Гэхдээ хүн болгонтой яриад байвал аюултай” гэж хариулсан юм.

Ром хотод цагаачилсан гадаадынхан их байдаг. Тэдний дунд хууль бусаар орж ирсэн хүмүүс байдаг бол гадаа гудамжинд зөвшөөрөлгүйгээр юм зарж, зогсож буй машины цонхыг арчиж мөнгө нэхдэг хүмүүс ч цөөнгүй байдаг. Гудамжинд юм зарж байснаа гэнэт яаран сандран бараагаа хамаж аваад цагдаагаас зугтан гүйж байсан хүмүүсийг ч багагүй харсан. Тиймээс ч би машиныхаа цонхыг хэзээ ч нээдэггүй байсан ба хүн юм асуусан ч сонсоогүй дүр эсгээд тоохгүй байхыг хичээдэг байсан.

Нэг удаа энэтхэг найзтайгаа хамт хоолонд явахаар болсон юм. Тэр үед охин маань найзын царайг харангуутаа миний чихэнд: “Ээж ээ, энэ хүн муу хүн биз дээ?” гэдэг байна. Цахилгаанд цохиулсан мэт санагдсан. Хичнээн сайхан зүйл нуршаад байсан ч хүнийг гаднах дүр

## Нивано Коошо

Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Такурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.



болон нөхцөл байдлаар нь ялгаж байсан миний сэтгэлийг охин маань сайвтар ажигласан байлаа.Охиныхоо хэлсэн үгийг сонсоод би өдий болтол хүнтэй хэрхэн яаж харьцаж ирснээ мэдэрч хариулах үг ч олдоогүй билээ.

Түүний дараа католик шашны сүсэгтнүүдийн “Фокорарэ”гэдэг байгууллагын хүмүүстэй хамт ажлаар гадагшаа явах болсон юм.Замын уулзвар дээр машин зогсож байхад халаасандаа дүүрэн салфеткан цаас чихчихсэн хүн ойртоод ирэв.Тэгтэл миний хажууд сууж байсан Наталиа гэдэг эмэгтэй ямар ч эрмэлзэлгүйгээр цонхоо онгойлгоод салфеткаг авангаа мөнгийг нь төлөөд,инээмсэглэн хэлэв:”Баярлалаа.Өнөөдөр сайхан өдөр байна шүү.Намайг Наталиа гэдэг.Таныг хэн гэдэг вэ?Хүүхэдтэй юу?Биеэ сайн бодоорой”.Хуучны танил мэт эгэл жирийнээр харьцсан тул би маш их гайхсан.Тэр эрэгтэй нутагтаа байгаа эхтэйгээ уулзсан мэт болсон байх.Гэрлийн дохио солигдож,машин хөдлөнгүүт тэр эрэгтэй хүүхдийнхээ зургийг атгасан өрөөсөн гараа бидний хойноос инээмсэглэн дохиж байсныг би одоо хүртэл мартдаггүй юм.Жолоо барьж явсан Мариа гуай “Манай Наталиа дандаа ингэдэг учраас машинаар дүүрэн салфеткан цаас байгаа”гэхэд бүгд инээн хөхрөв.Миний сэтгэл тайвширч сайхан болсон билээ.

Хамгийн чухал зүйл бол ямар хүнтэй учирсандаа биш харин хүнтэй учрахдаа өөрөө ямар хүн байх вэ гэдэг нь чухал болов уу.

# “Өмнөд Азид сургаалийн гэрлийг дахин...”

Өмнөд Азид сургааль дэлгэрүүлэх дүүргийн дарга,  
Бангладеш сүмийн тэргүүн

Аритоми.Норимаса

*Энэхүү илтгэл нь 2011 оны 3-р сарын 4-нд буюу Үүсгэн байгуулагчийн амин өдрийн хурал дээр тавигдсан бөлгөө.*

Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Илтгэл тавих үүрэг хүлээж аваад өөрийгөө эргэн харж чадсан явдалд сэтгэлийнхээ угаас талархаж байна. Би бээр өдгөө Бангладеш сүмийн тэргүүний үүргийг гүйцэтгэж байгаа. Тус үүргийг хүлээж аваад 3 жил болж байна. Бангладеш улс нь 1972 онд тусгаар тогтносон бөгөөд тусгаар тогтнолоос өмнө Зүүн Пакистани хэмээн нэрлэгддэг байв.

Бангладеш нь эртний энэтхэгийн Магада улс, өөрөөр хэлбэл Шагжамүни буддагийн сургаалиа айлдан дэлгэрүүлсэн газар боловч өдгөө дэлхийд хамгийн ядуу орон хэмээгддэг. Хэдий тиймч учирал ихтэй, сайхан сэтгэлтэй ард түмнээс бүрдсэн гайхалтай улс юм. Надтай хамт сургааль дэлгэрүүлэх үйлсэд ханцуй шамлан зүтгэж байгаа хүмүүс бол Гакурин сургуулийн гадаад оюутны ангийг төгссөн бангладешийн 7 залуу гишүүн юм. Тэдний ачаар би сургааль дэлгэрүүлж байна. Бангладеш сүм нь өдгөө 3763 айл өрхийг хамарсан гишүүнчлэлтэй бөгөөд сургааль дэлгэрүүлэх түшиц төв 14 газарт байгаа. Түүнчлэн бурхан багшийн ариун дүрийг залсан айл 953 –д хүрлээ.

Сүсгийн хоёрдугаар үе залгамжлагч болох би бээр оюутан байхдаа сургаальтай учирч, залуучуудын бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулж эхнэртэйгээ танилцан гэрлэж, хоёр хөөрхөн хүүтэй болсон. Нэртэй сайн компанид ч ажилтнаар орж, эрч хүч амтагдсан сайхан ажил ч хийдэг болсон юм.

Залуучуудын бүлгийн даргын үүрэг хүлээж аваад байхдаа биеэ тоосон би бээр удирдлагын албаныхны удирдамж, зөвөлгөөг дуулгавартай хүлээж авч чадалгүй үүргээсээ татгалзсан юм.

Улмаар ажил ихтэй завгүй гэсэн шалтгаанаар сүмийн үйл ажиллагаанд оролцохоо болив. Гагцхүү компанийхаа ажилд бие сэтгэлээ зориулж дээд тушаалтан болж, чадварлаг ажилтнуудаар ч хүрээлэгдэв. Улмаар янз бүрийн ажилыг амжилттай гүйцэтгэж, үе тэнгийн нөхөд маань атаархам хурдтайгаар ахиж дэд даргын

албанд томилогдсон би тэнгэрт нисэх нь холгүй байлаа. Сургааль ч бараг мартагдаж ирсэн юм.

Өдөр бүр ажлаасаа харих замдаа сүмээр ордог байсанаа болиж оронд нь архинд хөлчүүрсэн согтуу амьтан гэртээ харидаг болов. Судар хурж, сүм рүү очвол дээр юм биш үү гэж хэлүүлэх дээрээ тулаад байлаа. Тийм үед боловсон хүчний хугацаат нүүлгэн шилжүүлэлт болж, нэгэн байгуулгын ерөнхий даргаар томилогдов.

Шинэ албандаа очоод хоёр сар хэртэй болж ерөнхий хэлтсийн ажил гарт орж ирж байсан үе юм. Санхүүгийн албаны дарга амарсан байхтай санаандгүй таарч тухайн сарын санхүүгийн тайланг шалгатал их хэмжээний төлөөлөн төлөх мөнгө тусгагдсан байсан тул хачирхалтай санагдаж, ерөнхий хэлтсийн даргад нягтлан шалгах даалгавар өгсөн юм. Шалгалтын үр дүн нь төлөөлөн төлсөн мөнгө гэж байхгүй бөгөөд тухайн мөнгийг хэрхэн хэрэглэсэн нь тодорхойгүй гэсэн дүгнэлт гарав. Алга болсон мөнгө нэлээд их мөнгөн дүн байлаа. Улмаар тухайн мөнгийг хувьдаа завшсан ажилтан ч тодорхой болов.

Санхүүгийн үйл ажиллагаанд яагаад ийм хайнга хандсан юм бол, яагаад энэ хүртэл нь хэрэгсэхгүй орхисон юм бол гэгчлэн өмнөх хариуцлагатан болох ерөнхий даргыг дотроо зүхэв.

Бас яагаад би ийм зүйлтэй нүүр тулах гэж гэсэн бодол хэдэн сар надаас салсангүй. Энэ чигээр нь хэрэгсэхгүй орхивол юуг ч шийдвэрлэж чадахгүй гэж бодоод өмгөөлөгчөөс зөвлөгөө авч, тус ажилтныг шүүхэд өгөх бичиг баримтыг жин тан болгочихоод заавар авахаар захирал дээр оров. Тэгтэл захирал <<Нийтийн мөнгийг хувьдаа завшсан ялыг нь мэдээж үүрүүлэхгүй бол болохгүй. Гэвч мөнгийг хувьдаа завшсан ажилтан залуу хүн. Дээрээс нь өөрийн буруутайг хүлээж байгаа. Энд тэр хүний амьдралыг орвонгоор нь эргүүлчихэж болохгүй. Засрах боломж олгох хэрэгтэй. Засарч бүхнийг дахин шинээр эхлэх арга замыг заах учиртай хүн бол хариуцсан дарга, хариуцлагатан нь юм. Тиймээс тэр арга замыг нь бодож тусла>> хэмээв. Тэгж ч эрхлүүлж болохгүй

байхаа гэж бодсон ч захирлын заавар тул тус ажилтны эцэг эхтэй нь ярилцаж тохиролцоод хэсэгтээ азнахаар болов.

Түүнтэй зэрэгцээд тогтмол хугацаатайгаар өгдөг байсан эрүүл мэндийн шинжилгээний хариуны талаар ярилцах зүйл байна хэмээн эмнэлэгт дуудагдав. Эмнэлэг рүү яравчлан очтол цээжний рентоген зураг харуулаад “Аритомии гуай энийг хардаа, сүрье туссан байна. Мэргэжлийн эмнэлэг танилцуулах тул тэнд яаралтай шинжилгээ хийлгэнэ үү. Урт хугацаатайгаар эмнэлэгт хэвтэж магадгүй тул бодолтой байсан нь дээр байх” гэв. Нүд харанхуйлаад явчихав. Алба амьны ажил хэцүүдэхэд хүрч орхив.

Тийм байдалд хүрч байж сая нэг юм өөрийгөө эргэн харж чадсан юм.

Ямар ч байсан сүмийн тэргүүнээс зөвөлгөө авахаар болов. Сүмийн тэргүүний зөвөлгөө <<Аритомии гуай цаг нь иржээ>> гэсэн богинохон үг байсан ч надад бол тэр нь хангалттай байлаа.

Улмаар өөрийнхөө өдий хүртэлх явдал мөрийг эргэн харав. Өөрийн чадлаар олон арван ажлын ард амжилттай гарч ирсэн гэж бодож байсан ч үнэндээ бол олны ач түмний тусаар өнөөдөр хүртэл явж ирсэнээ, бас хувиа бодож довоо шарлуулвал болоо гэсэн бодолдоо баригдаад эргэн тойрныхоо хүмүүст талархах учиртайгаа мартчихсан өөрийгөө олж харсан юм. Дахиад бүхнийг эхнээс нь эхэлье хэмээн бодож туйлын үнэний сургаалийг дагаж амьдаръяа гэж шийдсэн юм.

Түүнээс хойш санал болгосон эмнэлэг дээр очиж шинжилгээ өгөв. Сүрьеэ тусвал жилээс дээш хугацаатайгаар эмнэлэгт хэвтэж эмчилгээ хийлгэхгүй бол болохгүй гэж олонтоо сонссон тул тэр тухай бодохоос ч халгаж байлаа. Гэвч сэтгэл дотроо ямар ч зүйл тохиолдсон бай бурхан багшийн бэлэг хэмээн хүлээж явъяа хэмээн хатуу шийдсэн байсан тул харсан хүн гайхширхаар хачин амгалан байлаа.

Шинжилгээний хариу эмчээс асуутал <<Яах аргагүй сүрьеэ байна. Үнэхээр сайн анзаарсан байна шүү. Энгийн шинжилгээгээр бол тэр бүр илэрдэггүй юм. Аритомигуайн байр суурийг бодолцож үзсэн ч долоо хоногт нэг удаа эмнэлэгт ирж эмчилгээнд ороод явбал зүгээр>> гэж хэлэв. Эмнэлэгт хэвтэхгүйгээр эмчилгээ хийлгэх болсондоо сэтгэл амарсан ч долоо хоног бүр Киосэ дүүрэгт байрлах эмнэлэг рүү очиж цусны болон бусад олон шинжилгээ өгч дараагаар нь ажилдаа явна гэдэг амаргүй даваа байлаа. Бас зургаан сарын турш нэг өдөр ч өнжилгүй сүрьеэгийн гурван төрлийн эм их хэмжээгээр уухгүй бол болохгүй байлаа. Түүнээс гадна эмний дагвар нөлөө ч их гэж хэлүүлэв. Эмээ уухаа зогсоовол бүрэн эмчилэгдэхгүй. Дуртай архиа ч ууж чадалгүй зургаан сар эмчилгээ хийлгэв.

Түүнчлэн сүмийн тэргүүнээс эрэгтэйчүүдийн

бүлгийн даргын үүрэг хүлээн авч үүрэгтээ бие сэтгэлээ зориулан зүтгэв. Үүргээрээ дамжуулж өөрийнхөө үзэл бодол, харах өнцөг өөрчлөгдөж байгааг мэдэрсэн юм. Өөрийг минь хүрээлсэн орчин ч гэсэн өөрчлөгдөж ирэв. Нэг их удалгүй нийтийн мөнгийг хувьдаа завшсан ажилтны эцэг эхтэй тохиролцох ажил саадгүй явагдаж эцэг эх нь бүх мөнгийг эргүүлэн төлөхөөр болсон юм.

Тус ажилтны эцэг эх байр болон газраа зарж аав нь ажлаас халагдсаны нөхөн даатгалаа бүгдийг нь өгч байж мөнгийг эргүүлэн төлж барагдуулсан юм. Үрээ гэсэн эцэг эх хоёрын дүр төрх, ээжийнх нь нулимсыг хараад тус ажилтныг сургаальтай учруулж үүнээс хойшхи амьдралаа хүн шиг аваад яваасай хэмээн хүсэж хэд хэдэн удаа холбоо барьж ярилцсан ч Косей кайтай учруулж чадаагүй юм.

Би энэ явдлаар дамжуулж эцэг эхийн ач мэддэггүй өөрийгөө анзаарч эцэг эхээсээ хүлцэл өчсөн юм. Түүнчлэн сүрьеэ маань ч гэсэн эмийн дагвар нөлөөгүй бүрэн эдгэрэв.

Өвчин маань эдгэсний дараагаар ажлаас халагдсаны тэтгэмжийг багасгах, байгуулгын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн шинэчлэх, ажилчдын тэтгэвэрт гарах насыг уртасгах, тэтгэвэрийн сангийн бүрдүүлэлт, их хэмжээний татварыг төлж барагдуулах зэрэг компани олон томоохон асуудлуудыг бүгдийг нь шийдвэрлэж чадсан юм. Эдгээр асуудал нь сургаальтай эргэн учраагүй бол шийдвэрлэж чадах зүйл биш байлаа. Сургаальтай дахин учирсны ачаар олон сайхан ажлын ард гарч өдий хүртэл явж ирсэн өнөөдрийн аз жаргал гэдэг маань олон түмний буянаар олж авсан зүйл гэдгийг улам гүн ухаарсан юм. Би сүрье тусаагүй бол, нийтийн мөнгийг хувьдаа завшсан ажилтан байгаагүй бол сургаальтай эргэн учирч чадахгүйгээр үл барам өмнөө байгаа олон асуудлаас нэгийг нь ч шийдвэрлэж чадахгүй байсан гэж боддог.

Түүнээс хойш үлдсэн амьдралаа хүний төлөө, бусдын төлөө зориульяа хэмээн зориг шулуудсан юм.

Чухам тийм үед өмнөд Азийн сүм байгуулагдаж, сургааль дэлгэрүүлэх үйлсэд хамтдаа зүтгэх хүсэлт надад ирсэн юм. Улмаар



жилд хэд хэдэн удаа Энэтхэггүй явж сургааль дэлгэрүүлэх үйлсэд туслахаар оролцсон юм. Бас Бангладеш сүм байгуулагдаж тус сүмийн тэргүүний үүргийг хүлээж авсан юм. Тэтгэвэрт гарахын өмнөхөн компаниас дараагийн ажлын пост төлөвлөчихсөн байсан ч учир байдлаа хэлж ажлаасаа гарах өргөдлөө өгсөн юм.

Байгуулагдаад удаагүй байгаа хаанахын ямар ч байгууллагад харагдах дүр зураг Бангладеш сүм дээр ч гэсэн адилхан байлаа. Бүх зүйл шинээр эхэлж байгаа болоод ч тэр үү эхэндээ санал бодлоо чөлөөтэй солилцож чадахгүй байв. Тэс өөр орны өөр хэл соёлд орж байгаа хүний хувьд мэдээжийн л зүйл.

Улмаар хагас жил болоод Үүсгэн байгуулагчийн сургаалийг ойлгоё хэмээн бодож бурханы шашны үндсэн сургаалийн сургалтыг эхлүүлсэн юм. Аажимдаа сургалтанд хамрагдах хүмүүс нэмэгдэж, сүм маань гэгээлэг хөл хөдөлгөөнтэй болж ирсэн юм. Сургааль дэлгэрүүлэх бусад үйл ажиллагаа ч идэвхитэй өрнөж ирэв. Тэр үед энэ сургааль үнэхээр гайхалтай гэдгийг дахин мэдэрсэн юм. Үүсгэн байгуулагчийн айлдсан сургааль гайхалтай болохоор хамаг чадлаараа айлдах хүний сэтгэлийг хөндөхгүй орхиж чадаагүй биз ээ.

Түүний дараагаар дүүрэг тус бүр дээр сургалт зохион байгуулж, байр байхгүй газарт бусад шашны сүм хийдийн лекцийн танхимийг хөлсөлж сургалтаа явуулсан юм. Сургалт өндөрлөнгүүт тус сүм хийдийн лам нар энэ сургааль эндүүрэл үгүй гайхалтай сургааль хэмээн батлаж байсан юм. Талархмаар зүйл нь олон арван лам нар дэмжиж хамтран ажилласан юм. Түүнчлэн энэ оны нэгдүгээр сарын 16-нд бангладеш даяарх лам нар сүмийн хуралд хүндэт зочноор оролцож, Косей кайгийн сургаалийг сонгох боломж ч олдсон юм. Нэг хөлгөний сургаалийг ойлгосон гэж бодогдсон.

Олон түмний ачаар Бангладеш сүмд сар бүр гишүүнээр элсэхийг хүссэн хүмүүс олноор ирдэг. Гишүүнээр элссэн ч сүм салбаруудын үйл ажиллагаанд олонтоо оролцоогүй бол бурхан багшийн гэрэлт дүрийг гэртээ залж чадахгүй. Бурхан залахаар очих үед тухайн айл бүр хамаатан саднаа цуглуулж ойролцоогоор 30 орчим хүн болсон байх нь элбэг байдаг. Ийнхүү бурхан багшийг залж байгаадаа талархан баяр болгон угтдаг юм. Улмаар тэнд оролцож байгаа хүмүүст хандаж сургааль айлдахдаа дахин дахин ухаарах зүйл гарч ирсээр байдаг.

Бурхан багшийг залсан айл нь нийт гишүүдийн гуравны нэг хувь нь болой. 2-р сард

Тама блокын залуучуудын бүлгийн гишүүд Бангладешид сургааль дэлгэрүүлэхээр ирж, 40 орчим айлд бурхан багшийн гэрэлт дүрийг залсан юм. Тама блокын залуучуудыг харж Бангладешийн залуу гишүүд их зүйлийг сурч авсандаа талархаж байгааг дамжуульяа.

Бангладешид залуучуудын бүлгийн үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаа. Өнгөрөгч онд болсон ARMS DOWN(Дэлхийн зэвсэглэлийн эсрэг тэмцэх аян)-ны гарын үсэг цуглуулах ажиллагаанд ч гэсэн бангладешийн залуу гишүүд нэгэн сэтгэлийн үзүүрт нэгдэн цугларч 183 мянган хүний гарын үсэг цуглуулсан юм. Түүнчлэн Бангладешийн залуу гишүүдийн бүртгэл 12172-т хүрч тоологдов. Өдгөөг хүртэл бусад үндэстэнтэй харилцаж байгаагүй бангладешийн жума, чукма, рака-ин үндэстний залуус ч гэсэн Косей кайд гишүүнээр элсэж эв найртайгаар залуучуудын бүлгийн үйл ажиллагаанд оролцож байгаа.

Түүнчлэн энэ оны хоёрдугаар сарын дөрвөнд Коошо(удаах ерөнхийлөгч) багшийг залж 10 мянга орчим залуу гишүүн цугларсан их номын хурлыг зохион байгуулсан юм. Бадатлгаат тооцоогоор 12,300 залуу тус номын хуралд оролцож, Коошо багшийн айлдварыг сонсож, эрч хүч, хүсэл мөрөөдлөөр өөрсдийгөө цэнэглэсэн залуус тус тусын салбар дээрээ сургаалийг улам бүр дэлгэрүүлээд явахаа тангарагласан юм. Энэхүү их хурлаар дамжуулж тэдори хийхдээ чадварлаг болсон залуу гишүүд олноор төрсөн юм.

Эдгээр залуус Бангладеш улсыг гайхалтай улс болгон хөгжүүлж, бурханы шашныг дахин сэргэн мандаах их үйлсийг бүтээнэ гэдэгт найдаж байгаа.

Шагжамүни будда сургаалиа дэлгэрүүлсэн Бангладеш улсад Косей кайгийн сургааль баттай түгэн дэлгэрч байгаа. Түүнчлэн өмнөд азид Цагаан Лянхуан Судар дахин түгэн дэлгэрч бат оршихыг үүсгэн байгуулагч маань хүсэн залбирдаг байсан билээ. Үүсгэн байгуулагчийн тэр мөрөөдлийг биелүүлэхийн тулд бангладеш сүмийн гишүүн тус бүр дор бүрээ хичээнгүйлэн зүтгэхээ тангараглаж байна.

Илтгэлийг маань чих тавин сонссон та бүхэнд их баярлалаа.







## Дайсны дүр төрхөө өөрийнхөө бурууг мэдэрдэг



Нүүрэнд хог наалдсан байсан ч толинд харахгүй л бол мэдэхгүй.Түүнийгээ анзаарангуутаа толинд харагдаж буй царайг янзлах биш юун түрүүнд өөрийнхөө царайг янзлана.

Номын Ариун Багш Ничирэн: ※” Тольгүй бол царайгаа харж чадахгүй.Дайсангүй бол буруугаа мэдрэхгүй”гэдэг байв.Ийнхүү тольгүй бол дүрсээ ч мэдэхгүй бол дайсантай болж л анх өөрийнхөө буруу зөрүүг мэдэрч,өөрийгөө засаж авч чадах боломжтой болдог байна.

Та бүгд ч Хоza дээр “Харьцаж буй хүн өөрийг чинь үзүүлж байгаа”гэж дуулсан байх.Хүнийг харахдаа үнэхээр тэгж бодож чаддаг бол хүний дутагдалыг буруутгах биш юуны өмнө өөрөө өөрийгөө эргэн харж,өөрийгөө засахаас өөр аргагүй болдог байна.

“Зуун сая шүүмжлэгчийн эрин үе”гэдэг өнөө үед маш олон хүн юм болгонд дургүйцэн шүүмжилдэг.Хүнийг шүүмжлэхээсээ өмнө эхлээд өөрийнхөө хөлийн улыг сайвтар харж,бие биенээ “миний дутагдалыг зааж өгдөг буянтай хүн”гэж хүлээн авч чадвал хүний нийгэм энх тайван,амьдрахад эвтэйхэн газар болж хувирана.

※Номын Ариун Багш Ничирэны “Каймокушё буюу сохролтоос чөлөөлөгдөх нь”гэсэн номны ишлэл үг



## Амьдралын зорилго

# Column

Таньд амьдралын тодорхой зорилго байгаа юу. Хоёр дахиа олодохгүй энэхүү гайхалтай хүний амьдралыг, утга учиртай өнгөрөөхийн тулд амьдралын зорилгоо тодорхой болгох нь нэн чухал юм.

Шагжамүни будда туйлын аз жаргалд хүрэх замыг бидэнд заасан. Тэр нь бурханы зам бөгөөд, зорилго нь бурхан болох болой.

Бурхан болно гэдгийг би бээр “Билгэ билгүүнээс үүдэх гэгээлэг чанар, нигүүлсэхүйгээс үүдэх дулаахан чанар бүхий нинжин сэтгэлтэй хүн болох” явдал хэмээн боддог. Ийм хүн болохын төлөө зорьж өдөр бүр сургаалийг хэрэгжүүлээд явахдаа бид дарма (ертөнцийн хууль)-г ухаарч мэдэрч чадна.

Би ч гэсэн дэлхийн хамгийн гэгээлэг, дулаахан, эелдэг хүн болохыг хүсдэг. Бас гэр бүлээ улам бүр үнэхээрийн гэгээлэг, дулаахан, эелдэг зөөлөн уур амьсгалтай болгомоор байна. Бас та бүхэнтэй хамтдаа Рисшо Косей кайг дэлхийн хамгийн гэгээлэг, дулаахан, эелдэг зөөлөн бурханы шашны байгууллага гэдгээр нь таниулж үйл ажиллагаанд нь оролцоод явахыг хүсдэг.

Дэлхий дахины хүмүүст дармаг дамжуулцгаая.

Олон улсад сургааль түгээх төвийн дарга  
Шоокоү Мизүтани

## “Цагаан Лянхуа судрын шинэ тайлбар” номны Хятад орчуулга хэвлэгдэн гарах болсонтой холбогдуулан лекц сименар зохион байгуулагдав

Үүсгэн байгуулагч Нивано Никкиогийн бичсэн “Цагаан Лянхуа судрын шинэ тайлбар” номны Хятад орчуулгыг өнгөрсөн намар Шанхай Гүжи хэвлэлийн газраас эрхлэн гаргалаа. Энэ үйл явдлаар тохиолдуулан илүү олон хүн Цагаан Лянхуа судртай учрах болтугай хэмээн 2 сарын 11-нд Тайпэй нийгэмлэг, 12-нд Тайнан нийгэмлэг дээр “Цагаан лянхуа судартай дотносох нь” нэрт лекц сименар зохион байгуулав. Тус семинарт 80 орчим хүн оролцсон ба түүн дотор нийгэмлэгийн гишүүд төдийгүй Тайваны сүм хийдийн лам нар ч байсан юм.

Тайпэй нийгэмлэг дээр болсон семинар дээр Удирдах зөвлөлийн дарга Чэн Зан Хоү мэндчилгээ дэвшүүлж, түүний дараагаар Рисшо Косей Кай нийгэмлэгийн олон улсын зөвлөх доктор Мириам Рэвэрин лекц тавьж, Цагаан Лянхуа

судрын “500 шавь бурхан болох баталгаа авсан нь хэмээх 8-р бүлэг” ба “Түүнчлэн ирсэн насны хэмжээ хэмээх 16-р бүлэг”-ээс иш татаж сударт өгүүлсэн тус нийгэмлэгийн үндсэн үйл юу болохыг ойлгомжтойгоор тайлбарлаж өгөв. Лекц уг номны орчуулагч номлогч Ши Зэн Диний яриагаар үргэлжилсэн ба тэрээр яриандаа Үүсгэн байгуулагч Ниваногийн хүн чанар, сүсэг бишрэлийн талаарх үзэл санааны тухай дурдсанаас гадна сүсэг бишрэлээ гүнзгийрүүлж, билиг оюуныг эзэмшихийн тулд “Цагаан Лянхуа сударт суралцаж, эхлээд гэр бүлээрээ бурхан шүтэх нь чухал” хэмээн онцгойлон дурдлаа.

Тайнан нийгэмлэг дээр доктор Рэвэрин, номлогч Ши Зэн Дин гуай нар мөн адил лекц тавьсан ба түүний дараа тус нийгэмлэгийн тэргүүн Зуан Жин Ён мэндчилгээ дэвшүүлэв. Тэрээр “Олон хүмүүстэй учрахын тулд энэхүү номоор дамжуулж сургаалд суралцаж, сургаал түгээх үйлд хичээнгүйлэн зүтгэнэ” хэмээн ярьж байв.

※Хятад хэл дээрх “Цагаан Лянхуа судрын шинэ тайлбар”-ыг хэвлэлийн газраас худалдан авах боломжтой. Дараах хаягаар холбоо барина уу. Имэйл: [kspub@kosei-shuppan.co.jp](mailto:kspub@kosei-shuppan.co.jp)



Тайнан нийгэмлэг, номлогч Ши Зэн Дин гуайн лекцний байдал



Таипэй нийгэмлэг, Ph.D Мириам Рэвэриний лекцний байдал

## Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганума Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэгцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайваныг зорьдог юм.



## SHAN-ZAI Volume 78 (March 2012)

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв.

Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail : [shanzai@kosei-kai.or.jp](mailto:shanzai@kosei-kai.or.jp)

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

# Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

# 2012

## Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

## Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,  
CA 92612, U.S.A.  
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432  
e-mail: info@rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

## Branch under RKINA

**Rissho Kosei-kai of Tampa Bay**  
2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA  
Tel: (727) 560-2927  
e-mail: rktampabay@yahoo.com  
<http://www.rkina.org/tampabay>

## Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang  
Bangkok 10310, Thailand  
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218  
e-mail: thairissho@csloxinfo.com

## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633  
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

**Rissho Kosei-kai Maui Dharma Center**  
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.  
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

**Rissho Kosei-kai Kona Dharma Center**  
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96740, U.S.A.  
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567  
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

**Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio**  
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745  
e-mail: dharmasanantonio@gmail.com

**Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**

**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437  
e-mail: rkksf@sbcglobal.net

**Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center**  
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.  
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261  
e-mail: rkseattle@juno.com

**Rissho Kosei-kai of Sacramento**

**Rissho Kosei-kai of San Jose**

**Rissho Kosei-kai of Vancouver**

**Lotus Buddhist Circle**  
851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.  
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499  
e-mail: koseiny@aol.com

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.  
Tel & Fax: 1-847-394-0809  
e-mail: murakami4838@aol.com

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.  
Tel & Fax: 1-405-943-5030  
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

**Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls**  
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.  
Tel: 1-541-810-8127

**Rissho Kosei-kai, Dharma Center of Denver**  
1571 N Race St., Denver, Colorado 80206, U.S.A.  
Tel: 1-303-810-3638

**Rissho Kosei-kai Dharma Center of Dayton**  
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
CEP 04116-060, Brasil  
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304  
e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

**Rissho Kosei-kai de Mogi das Cruzes**  
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
CEP 08730-000, Brasil  
Tel: 55-11-4724-8862

## Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100  
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

## Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,  
Taichung City 401  
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

## Rissho Kosei-kai of Jilong

## Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701  
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

## Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,  
Pingtung County 900  
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

## Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea  
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696  
e-mail: krkk1125@hotmail.com

## Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,  
Republic of Korea  
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

## Korean Rissho Kosei-kai of Masan

## Branches under the Headquarters

### Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,  
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic  
of China  
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

### Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,  
Ulaanbaatar, Mongolia  
Tel & Fax: 976-11-318667  
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sukhbaatar**

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

**Rissho Kosei-kai of Sakhalin**

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk  
693000, Russian Federation  
*Tel & Fax:* 7-4242-43-78-56

**Rissho Kosei-kai (Geneva)**

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland  
*Tel:* 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053  
*e-mail:* rkkgva@wcc-coe.org

**Rissho Kosei-kai of the UK****Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy  
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Paris**

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France  
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Sydney****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224  
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

**Rissho Kosei-kai of South Asia Division**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-2850238

**Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* info.thairissho@gmail.com

**Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-2850238

**Rissho Kosei-kai of Dhaka**

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,  
Dahka Cand.-1206, Bangladesh  
*Tel:* 880-2-8316887

**Rissho Kosei-kai of Mayani**

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Sri Lanka**

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka  
*Tel:* 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,  
Sri Lanka

**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Galle**

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

**Branches under the South Asia Division****Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,  
New Delhi-110019, India  
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713  
*e-mail:* sakusena@hotmail.com

**Rissho Kosei-kai of West Delhi**

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar  
New Delhi-110018, India

**Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,  
KOLKATA 700094, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal  
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832  
*e-mail:* nrkk@wlink.com.np

**Rissho Kosei-kai of Lumbini**

Shantiban, Lumbini, Nepal

**Rissho Kosei-kai of Singapore****Other Groups****Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,  
Shanghai 200081 China

# Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

# 2012

## Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

## Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,  
CA 92612, U.S.A.  
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432  
e-mail: info@rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

## Branch under RKINA

**Rissho Kosei-kai of Tampa Bay**  
2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA  
Tel: (727) 560-2927  
e-mail: rktampabay@yahoo.com  
<http://www.rkina.org/tampabay>

## Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang  
Bangkok 10310, Thailand  
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218  
e-mail: thairissho@csloxinfo.com

## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.  
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633  
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

**Rissho Kosei-kai Maui Dharma Center**  
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.  
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

**Rissho Kosei-kai Kona Dharma Center**  
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96740, U.S.A.  
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.  
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567  
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

**Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio**  
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.  
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745  
e-mail: dharmasanantonio@gmail.com

**Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**

**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.  
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437  
e-mail: rkksf@sbcglobal.net

**Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center**  
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.  
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261  
e-mail: rkseattle@juno.com

**Rissho Kosei-kai of Sacramento**

**Rissho Kosei-kai of San Jose**

**Rissho Kosei-kai of Vancouver**

**Lotus Buddhist Circle**  
851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.  
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499  
e-mail: koseiny@aol.com

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.  
Tel & Fax: 1-847-394-0809  
e-mail: murakami4838@aol.com

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.  
Tel & Fax: 1-405-943-5030  
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

**Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls**  
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.  
Tel: 1-541-810-8127

**Rissho Kosei-kai, Dharma Center of Denver**  
1571 N Race St., Denver, Colorado 80206, U.S.A.  
Tel: 1-303-810-3638

**Rissho Kosei-kai Dharma Center of Dayton**  
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,  
CEP 04116-060, Brasil  
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304  
e-mail: risho@terra.com.br <http://www.rkk.org.br>

**Rissho Kosei-kai de Mogi das Cruzes**  
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,  
CEP 08730-000, Brasil  
Tel: 55-11-4724-8862

## Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100  
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

## Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,  
Taichung City 401  
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

## Rissho Kosei-kai of Jilung

## Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701  
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

## Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,  
Pingtung County 900  
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

## Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea  
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696  
e-mail: krkk1125@hotmail.com

## Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,  
Republic of Korea  
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

## Korean Rissho Kosei-kai of Masan

## Branches under the Headquarters

### Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,  
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic  
of China  
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

### Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,  
Ulaanbaatar, Mongolia  
Tel & Fax: 976-11-318667  
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sukhbaatar**

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

**Rissho Kosei-kai of Sakhalin**

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk  
693000, Russian Federation  
*Tel & Fax:* 7-4242-43-78-56

**Rissho Kosei-kai (Geneva)**

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland  
*Tel:* 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053  
*e-mail:* rkkgva@wcc-coe.org

**Rissho Kosei-kai of the UK****Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy  
*Tel:* Contact to *Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Paris**

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France  
*Tel:* Contact to *Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Sydney****International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan  
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224  
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

**Rissho Kosei-kai of South Asia Division**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-2850238

**Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang  
Bangkok 10310, Thailand  
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218  
*e-mail:* info.thairissho@gmail.com

**Rissho Kosei-kai of Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
*Tel & Fax:* 880-31-2850238

**Rissho Kosei-kai of Dhaka**

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,  
Dahka Cand.-1206, Bangladesh  
*Tel:* 880-2-8316887

**Rissho Kosei-kai of Mayani**

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,  
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Sri Lanka**

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka  
*Tel:* 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,  
Sri Lanka

**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Galle**

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

**Branches under the South Asia Division****Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,  
New Delhi-110019, India  
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713  
*e-mail:* sakusena@hotmail.com

**Rissho Kosei-kai of West Delhi**

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar  
New Delhi-110018, India

**Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,  
KOLKATA 700094, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,  
Kathmandu, Nepal  
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832  
*e-mail:* nrkk@wlink.com.np

**Rissho Kosei-kai of Lumbini**

Shantiban, Lumbini, Nepal

**Rissho Kosei-kai of Singapore****Other Groups****Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,  
Shanghai 200081 China